



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 15-ны өдөр

Дугаар А/09

Эрдэнэт

Г “Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах
мэргэжлийн болон тусгай зориулалтын
ангийг шинэчлэн батлах тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйл 1. 2, 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны “Мэргэжлийн ангийн дүрэм батлах тухай” 75 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн анги, тусгай зориулалтын анги, хээрийн эмнэлгийн бүлэг, яаралтай тусламжийн бүлэг, эм, эмнэлгийн хэрэгслийн бүлэг, цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг, зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг, ар тал, хангалт, аж ахуйн тасаг, халдвар эсэргүүцэх хөдөлгөөнт тасаг, тээврийн хэсэгтэй байхаар бүтцийг баталсугай.

2. Эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, мэргэжлийн ангийн дарга, гишүүдийн ажлын чиг үүргийг хоёрдугаар, гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны бүтцийн зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын хавсралтын дагуу шинэчлэн боловсруулан хэрэгжүүлж, шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг мэргэжлийн байгууллагад хүргэн, тогтмол холбоотой ажиллахыг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орлогч, ажилтнуудад даалгасугай.

4. Мэргэжлийн ангийн чиг үүргийн дагуу тусгай зориулалтын бүлэг, тасаг, хэсгийн ажлыг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг ЭМГ-ын Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-д үүрэг болгосугай.

4. Мэргэжлийн ангийг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, үүрэг гүйцэтгэх багаж хэрэгсэлээр хангах, гамшгаас хамгаалах ангилалын сургалт явуулахад тус тус шаардагдах төсвийг гаргаж зарцуулахыг Салбарын санхүү бүртгэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны ~~12~~ дугаар сарын
~~11~~ -ний өдрийн ~~109~~ дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Мэргэжлийн ангийн дарга- Эрүүл мэндийн газрын дарга
2. Орлогч- ЭМГ-ын Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
3. Төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан
 - ЭМГ-ын Хүний нөөцийн мэргэжилтэн
 - ЭМГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан ажилтан
 - ЭМГ-ын Эрүүл мэндийн статистик мэдээлэлийн мэргэжилтэн
 - ЭМГ-ын Эх хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
4. Холбоо зарлан мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан хариуцсан ажилтан:
 - ЭМГ-ын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн
 - ЭМГ-ийн Мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
 - ЭМГ-ын Зураглаач
 - Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
5. Ар тал хангалт хариуцсан ажилтан:
 - ЭМГ-ын Эдийн засагч
 - ЭМГ-ын Салбарын санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтан
6. Аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан:
 - ЭМГ-ын Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
 - ЭМГ-ын Халдварт өвчин тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
 - ЭМГ-ын Дархлаажуулалт, зоонозын асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 02 дугаар сарын
15-ний өдрийн 419 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



МЭРГЭЖЛИЙН АНГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

Мэргэжлийн ангийн дарга дараах үүрэг хүлээнэ:

а. Гамшгийн өмнөх үед:

1. Гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх;
2. Жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээг маягтын дагуу гаргаж, харъяалах Онцгой байдлын байгууллагад хүргүүлэх;
3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах;
4. Мэргэжлийн ангийн бэлэн байдал, сэтгэл зүйн бэлтгэл, бүлэг, хэсгүүдийн харилцан шуурхай үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх;
5. Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

б. Гамшгийн үед:

1. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
2. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;
3. Бусад төрөл, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагааг зохион байгуулах;

в. Гамшгийн дараах үед:

1. Бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчилиийг арилгах арга хэмжээ авах;

Мэргэжлийн ангийн даргын орлогч дараах үүрэг хүлээнэ:

а. Гамшгийн өмнөх үед:

1. Мэргэжлийн ангийн даргын эзгүйд түүний үүргийг орлон гүйцэтгэх;

2. Мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

б. Гамшгийн үед:

1. Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахад мэргэжлийн ангийн даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хөрш байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах;
2. Гамшгийн голомтод мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

в. Гамшгийн дараах үед:

1. Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах;

Төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтанууд дараах үүрэг хүлээнэ:

а. Гамшгийн өмнөх үед:

1. Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлэх;
2. Гамшгаас хамгаалах дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

б. Гамшгийн үед:

1. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

в. Гамшгийн дараах үед:

1. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

Холбоо, зарлан мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

а. Гамшгийн өмнөх үед:

1. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
2. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж шалгах, тухай бүр тодотгох;
3. Бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор

ажиллах дадлага эзэмшүүлэх;

4. Гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль явуулахад шаардлагатай танхим, дадлагын талбай бэлтгэх, бие бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулах;
5. Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэрэмжлүүлэг, гамшиг, ослын нөхцөл байдал, хор уршгийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдад таниулах, сурталчлах, гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх сурталчилгааны материалаар хангах зэрэг ажлыг зохион байгуулах

б. Гамшгийн үед:

1. Гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргыг холбоо, мэдээллээр хангах;
2. Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;

в. Гамшгийн дараах үед:

1. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх, нөхөн сэлбэх;

Аюулгүй байдал хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

а. Гамшгийн өмнөх үед:

1. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах;
2. Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;
3. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;
4. Галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт болон хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих, объектын харуул хамгаалалтад хяналт тавих;

б. Гамшгийн үед:

1. Гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;

2. Хүч хэрэгслийг гамшиг, ослын голомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
3. Гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

в.Гамшгийн дараах үед:

1. Мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, аюулгүй байдлыг сайжруулах;

Хангалт хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

а.Гамшгийн өмнөх үед:

2. Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, хангалтын төлөвлөгөө боловсруулах,
3. Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;
4. Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;

б. Гамшгийн үед:

1. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг байр, цэвэр ус, хоол хүнс, эм, ороох боох материалаар хангах ажлыг зохион байгуулах;
2. Голомтод үүрэг гүйцэтгэж байгаа техник, тоног төхөөрөмжийг шатах тослох материалаар хангах;

в.Гамшгийн дараах үед:

1. Хохирлын үнэлгээг хийж, мэргэжлийн ангийн даргыг мэдээллээр хангах;

Мэргэжлийн ангийн гишүүний үүрэг:

Мэргэжлийн ангийн гишүүн дараах үүрэг хүлээнэ:

а.Гамшгийн өмнөх үед:

1. Мэргэжлийн ангийн сургалт, дадлага сургууль, бусад нэгдсэн арга хэмжээнд оролцож өөрийгөө хөгжүүлэх;
2. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ашиглах, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг ажиллуулах дадлага эзэмшсэн байх;
3. Хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах;
4. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшсэн байх;
5. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг судлах;
6. Өөртөө болон бусаддаа тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх;

б.Гамшгийн үед:

1. Удирдлагын шийдвэрээр гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх;
2. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах;

в.Гамшгийн дараах үед:

1. Эрүүл мэнд, сэтгэл зүйн эмчилгээнд хамрагдах
2. Хувийн бэлтгэлийг хангаж дараагийн томилгоот үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх;

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 02 дугаар сарын
15-ний өдрийн 1/09 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

9043446 202001036

